



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 13

Номгон

Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр Жинст, Богд, Баян-Өндөр, Баян-Овоо, Эрдэнэцогт, Бууцагаан сумуудад шинээр гаргасан 123 239 941 төгрөгийн өртөг бүхий 7 ширхэг өрөмдмөл худгуудын эзэмшигчийг нэгдүгээр, Баянхонгор сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 6 нэрийн 13667000 төгрөгийн өртөг бүхий хоёрдугаар хавсралтад заагдсан хөрөнгийн эзэмшигчээр аймгийн Цагдаагийн газрыг тогтоож, байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэсүгэй.

2. Баянхонгор сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 20,0 сая төгрөгөөр худалдан авсан Toyota Alphard маркийн автомашины эзэмшигчээр Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрыг тогтоосугай.

3. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.

3.1 Хөрөнгийг бүртгэх ажлыг тухайн байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2 Эзэмшигч тогтоосон автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээг холбогдох байгууллагын нэр дээр шилжүүлэх;

3.3 Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.4 Энэ тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 02 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх;

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.


ДАРГА  Ц.ОТГОНБАЯР 



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 31-ний
өдрийн 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ШИНЭЭР ГАРГАСАН
ӨРӨМДМӨЛ ХУДАГТ ЭЗЭМШИГЧ ТОГТООСОН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Худгийн нэр	Координат		Худгийн гүн/м	Үндэрт /л,сек	Статик түвшин	Динамик түвшин	Насос суулах гүн/м	Насос		Мотор		Худгийн нийт үнэ/төг/	Эзэмшигч нэр
			Өргөрөг	Уртраг						Марк	Үнэ/мян. н.төг/	Марк	Үнэ/мян. төг/		
1	Жинст	Аашнай	45.18.42	99.55.23	45	1	7	13	28	100QJD	250,0	КАМА	650,0	16512596	ЗДТГ
2	Баян-Өндөр	Мэнгэт толгой	44.59.35	98.17.56	45	1.5	4	10	25	100QJD	250,0	КАМА	650,0	18112425	ЗДТГ
3	Бууцагаан	Зүлэгт	46.19.54	99.054	39	1.2	4	8	30	100QJD	250,0	КАМА	650,0	17208506	ЗДТГ
4	Бууцагаан	Муруй нурууны адгийн худаг	46.00.56	99.03.16	30	0.6	12	20	25	100QJD	250,0	КАМА	650,0	16400000	ЗДТГ
5	Богд	Гүн худаг	45.25.28	101.05.03	40	1	18	22	30	100QJD	450,0	КАМА	675,0	18401804	ЗДТГ
6	Баян-Овоо	Дунд ар	46.19.39	100.36.49	60	0.6	35	38	48	100QJD	450,0	КАМА	675,0	18804610	ЗДТГ
7	Эрдэнэцогт	Баянзүрхийн хонхор	45.18.12	100.59.81	45	1	5	12	0	100QJD	250,0	КАМА	675,0	17800000	ЗДТГ
														123 239 941,00	



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 31-ний
өдрийн 13 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
БЭЛТГЭСЭН ХӨРӨНГӨД ЭЗЭМШИГЧ ТОГТООСОН ЖАГСААЛТ

№	Хэрэгжүүлсэн төслийн нэр	Хэмжээ	Тоо хэмжээ	Бүртгэлд тусгах дүн	Хөрөнгийн эх үүсвэр	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Эзэмшигч байгууллага	Тайлбар
1	Lenovo notebook n12	ш	1	1 250 000,00	Баянхонгор сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр	"NANO SHOP"	Цагдаагийн газар	Үндсэн хөрөнгөд бүртгэх
2	Asus notebook i3	ш	1	1 350 000,00		"NANO SHOP"	Цагдаагийн газар	Үндсэн хөрөнгөд бүртгэх
3	Драгер AL9000L	ш	1	589 000,00		"Бодь электроникс" ХХК	Цагдаагийн газар	Үндсэн хөрөнгөд бүртгэх
4	Согтолт тандагч AL-1100	ш	2	1 278 000,00		"Бодь электроникс" ХХК	Цагдаагийн газар	Үндсэн хөрөнгөд бүртгэх
5	Бэлэн бус торгуулийн машин RG740	ш	4	6 400 000,00		"Бодь электроникс" ХХК	Цагдаагийн газар	Үндсэн хөрөнгөд бүртгэх
6	Бэлэн бус хэвлэх багаж SPP-R200	ш	4	2 800 000,00		"Бодь электроникс" ХХК	Цагдаагийн газар	Үндсэн хөрөнгөд бүртгэх
	Дүн		13	13 667 000,00				

оОо